

МОНГОЛ ХЭЛ

2011

ХУВИЛБАР А

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж:

1. Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгавруудыг гүйцэтгээрэй.
2. Эхээс сонгож авсан өгүүлбэр, үгсийг эхтэй нь холбон уншиж ажиглаарай.
3. Сонгох даалгавруудын зөвхөн нэгийг сонгоорой. (Даалгавар бүр 2 оноотой)

Тогоруу

Хос тогоруу сайр даган хөлөө дээр дээр өргөн зэгзэгнэн алхана. Би сайрын хөх хайрган дунд тогорууны өндгийг үзэлгүй сүүдрээ хүргэчих вий гэхээс зүрх эмзэглэнэ. Хөөрхий нялх үрийг нь сүүдрээрээ хиртүүлэхүй намайг хараана гэхээс өвөөгийн хэлсэн үг өр зүрх өвтгөнө. “Ай даа, хүү минь, тогорууг уурлуулж болдоггүй юм. Төмөр дөрөөний сэнжийг сэтэртэл хараадаг амьтан” гэж захидаг сан. Өндөр хөх тогорууг өнөөдөр би их л ойроос хараад өрөвдөв. Хөөрхий тэр шувуу хүнийг тийм сүрхий хараадаг гэж үү? Лав үгүй байх аа. “Хүнд муу биеэрээ дэлхийг цөмлөчих вий гэсэн шиг ийм хөнгөн гишгэж байгаа амьтан чинь дөрөөний сэнжийг яаж сэтэртэл хараах билээ” гэхээс өвөөгийн үгэнд үл итгэв. Миний бодлыг батлах шиг мөнөөх хоёр тогоруу улам ч зөөлөн зөөлөн гишгэсээр зэгзэгнэн айсуу.

(Н.Өлзийбат)

1. Эхийн үйл явдлыг зөв дараалалд оруулсан хэсгийг олоорой.
 1. Хоёр тогоруу зэгзэгнэн айсуу.
 2. Хөөрхий тэр шувуу хүнийг тийм сүрхий хараадаг гэж үү?
 3. Ийм хөнгөн гишгэж байгаа амьтан чинь дөрөөний сэнжийг яаж сэтэртэл хараах билээ.
 4. Хос тогоруу зэгзэгнэн алхана.
 5. Төмөр дөрөөний сэнжийг сэтэртэл хараадаг амьтан гэж захидаг сан.

A. 1, 5, 2, 3, 4	B. 1, 5, 3, 2, 4	C. 4, 5, 2, 3, 1
D. 4, 5, 3, 2, 1	E. 2, 4, 3, 5, 1	
2. Дээрх эхийн жинхэнэ нэрийг утгаар нь зүйлчилбэл ямар утгын зүйлчлэл байхгүй байна вэ?

A. Хүний зүйл	B. Ургамлын зүйл	C. Амьтны зүйл
D. Гариг эрхсийн зүйл	E. Хүний бүтээсэн зүйл	
3. Дээрх эхийн хэв маягийг тодорхойлно уу.

A. Тоочимж	B. Эргэцүүлэмж	C. Тайлбарламж
D. Хүүрнэмж	E. Учирламж	
4. Дээрх эх найруулгын ямар төрлөөр бичигдсэн байна вэ?

A. Албан бичгийн найруулга	B. Уран зохиолын найруулга
C. Сонин нийтлэлийн найруулга	D. Ярианы найруулга
E. Эрдэм шинжилгээний найруулга	
5. Дээрх эхийн сэдвийг олоорой.

A. Тогорууны тухай	B. Ахмадын сургаалыг дагаж мөрдөх тухай
C. Элбэрэл хайрын тухай	D. Байгалийн тухай
E. Сониуч хүүгийн тухай	
6. Дээрх эхийн гол санааг илэрхийлсэн тулгуур өгүүлбэрийг олоорой.
 - A. Өндөр хөх тогорууг өнөөдөр би их л ойроос хараад өрөвдөв.
 - B. Дэлхийг цөмлөчих вий гэсэн шиг ийм хөнгөн гишгэж байгаа амьтан чинь дөрөөний сэнжийг яаж сэтэртэл хараах билээ.
 - C. Төмөр дөрөөний сэнжийг сэтэртэл хараадаг амьтан.
 - D. Тогорууны өндгийг үзэлгүй сүүдрээ хүргэчих вий гэхээс зүрх эмзэглэнэ.
 - E. Өвөөгийн үгэнд үл итгэв.
7. Дээрх эх хэдэн цогцолбороос бүтсэн байна вэ?
 - A. “Хос тогоруу... зүрх эмзэглэнэ”, “Хөөрхий нялх үрийг нь... захидаг сан”, “Өндөр хөх тогорууг... үл итгэв”, “Миний бодлыг... зэгзэгнэн айсуу” гэсэн 4 цогцолбор
 - B. “Хос тогоруу...захидаг сан”, “Өндөр хөх тогорууг... зэгзэгнэн айсуу” гэсэн 2 цогцолбор
 - C. “Хос тогоруу... зүрх эмзэглэнэ”, “Хөөрхий нялх үрийг нь... захидаг сан”, “Өндөр хөх тогорууг... зэгзэгнэн айсуу” гэсэн 3 цогцолбор
 - D. 1 цогцолбороос бүтсэн бичил эх
 - E. “Хос тогоруу ... зүрх эмзэглэнэ”, “Хөөрхий нялх үрийг нь... захидаг сан”, “Өндөр хөх тогорууг... хараадаг гэж үү?”, “Лав үгүй байх аа...үл итгэв”, “Миний бодлыг... зэгзэгнэн айсуу” гэсэн 5 цогцолбор

8. Дээрх эхийн тулгуур үгсийг зөв бүлэглэсэн хэсгийг олоорой.
 А. Өвөө, төмөр дөрөө, үг, бодол, өндөг, сүүдэр, зүрх, шувуу, үр
 В. Төмөр дөрөө, тогоруу, хайрга, сүүдэр, шувуу, би, хүү, өндөг, үг
 С. Хос тогоруу, сайр, үр, өндөг, сүүдэр, хүү, бие, өвөө, үг
 D. Тогоруу, би, өндөг, үр, сүүдэр, өвөө, төмөр дөрөө, үг, бодол
 E. Хүн, нялх үр, бодол, дөрөөний сэнж, шувуу, дэлхий, өр зүрх, үг, би
9. Дараах өгүүлбэрээс шинэ санааг илэрхийлсэн дүрслэх ур маягийг тодорхойлоорой.
 “Төмөр дөрөөний сэнжийг сэтгэртэл хараадаг амьтан”
 А. Тойруулал В. Төлөөлөл С. Ихэсгэл
 D. Адилтгал E. Зүйрлэл
10. Дараах тодорхойлолтын цэгийн оронд тохирох үгийг олоорой.
 Бодит ба хийсвэр зүйлээс үүдэн зохиол бичих болсон шалтгаан, сэдэц санааг.....гэнэ.
 А. Зорьсон санаа В. Төрсөн санаа С. Гол санаа
 D. Шинэ санаа E. Төгс санаа
11. Бүгд өгүүлэгчийн баймж, үнэлэмж, сэтгэл хөдлөлийн өнгө аяс илтгэсэн хэсгийг олоорой.
 А. ...хүргэчих вий, ...захидаг сан, ...хараадаг гэж үү?, ...Лав үгүй байх аа
 В. ...Хөөрхий нялх үрийг нь, ...уурлуулж болдоггүй юм, ...цөмлөчих вий, ...зүрх эмзэглэнэ
 С. ...батлах шиг, ...амьтан чинь, ...хараах билээ, ...зүрх өвтгөнө
 D. ...улам ч, ...үл итгэв, ...их л ойроос, ...зэгзэгнэн айсуу
 E. ...Хөөрхий тэр шувуу, ...гэсэн шиг, хүргэчих вий, ...өрөвдөв
12. Дараах өгүүлбэрийн утгын харьцааг тодорхойлоорой.
 “Хөл хучиж цай чанах гэсний хэрэггүй. Хүн болгосон гэж өр төлөх ч хэрэггүй”
 А. Зүйлчилсэн В. Төсөөт С. Эсрэг
 D. Ойролцоо E. Ижил
13. Дараах өгүүлбэрийн баймж утгыг тодорхойлоорой.
 “Шүүдрийн дусал цуглуулах гэж цагаа дэмий үрэх хэрэггүй”
 А. Зайлшгүй баймж В. Бодит баймж С. Үнэн магадлалт
 D. Хэм хэмжээт баймж E. Таамагласан баймж
14. “Санаа алдах” гэсэн өвөрмөц хэлцтэй ойролцоо утгатай хэлцийг ол.
 А. Нойр алдах В. Ам алдах С. Шүүрс алдах
 D. Нүд алдах E. Ухаан алдах
15. Ойролцоо болон эсрэг утгатай үг хоёулаа орсон хэсгийг ол.
 А. Цувж явсан барснаас, цуглаж суусан шаазгай дээр
 В. Ажил хийвэл дуустал, давс хийвэл уустал
 С. Илжиг таргалбал, эзнээ өшиглөх
 D. Зэмлэх үгийн ил нь, магтах үгийн далд нь
 E. Олзны үүдийг нээж, гарзны хаалгыг хаах
16. Дараах үгсийг уншаад, харь үгийг ол.
 А. Бууз В. Тэмцээн С. Ногоо D. Үнэг E. Хөдөө
17. Дараах үгсээс дуурайх язгуур бүхий хэсгийг олоорой.
 А. Бүлтийх, шоолох, ярзайх, тонгойх
 В. Тарих, давтах, хөдөлмөрлөх, үйлдэх
 С. Суллах, нүдлэх, ганзагалах, хайрлах
 D. Хоржигнох, ганганах, тогших, цангинах
 E. Жингэнэх, годгонох, хурхирах, сандрах
18. Дараах үгийг бүтцээр зөв задалсныг олоорой.
 А. Эвхэгд + ж В. Эвх + гд + 0 + ж С. Эвх + г + д + 0 + ж
 D. Эвхэгд + 0 + 0 + ж E. Эвх + г + дэж
19. Дараах өгүүлбэрийн шинжид тохирох тодорхойлолтыг олоорой.
 “Намрын нуур ангираа гүвлээ”
 А. Энгийн, хүүрнэх, гурван бүрэлдэхүүнт, цөм өгүүлбэр
 В. Энгийн, хүүрнэх, гурван бүрэлдэхүүнт, цөм бус өгүүлбэр
 С. Энгийн, хүүрнэх, хоёр бүрэлдэхүүнт, цөм өгүүлбэр
 D. Энгийн, хүүрнэх, хоёр бүрэлдэхүүнт, цөм бус өгүүлбэр
 E. Энгийн, захирах, гурван бүрэлдэхүүнт, цөм өгүүлбэр

20. Дараах өгүүлбэрийн бүтцийг тодорхойлоорой.
 "...Хуурын боолтыг унагахад нь
 Ногоон халзан морины цагаан хөлхтэй зовхи
 Нойтон байж билээ"
 А. Цагийн байц гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
 В. Орны байц гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
 С. Болзлын байц гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
 D. Шалтгааны байц гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
 E. Өгүүлэгдэхүүн гишүүн өгүүлбэртэй харилцан угсарсан нийлмэл өгүүлбэр
21. Утгазүйжсэн холбоо үг бүхий хэсгийг олоорой.
 А. Ангираа гүвэх, буурал бүүвэй, эгчийн алчуур
 В. Хуурын боолт, буурал бүүвэй, хөлхтэй зовхи
 С. Энэ дурдатгал, өрхний оосор, манай говийнхон
 D. Тэвхэн дээгүүр, тонгочиж бай-, эмтрэх шиг
 E. Бурхан бол-, хоног хураа-, заншил эмтэр-
22. Дараах өгүүлбэрийн онцолсон үг ямар гишүүн болох вэ?
 "Хоймроо асан тонгочиж байгаад..."
 А. Өгүүлэгдэхүүн В. Өгүүлэхүүн С. Байц
 D. Шууд тусагдахуун E. Шууд бус тусагдахуун
23. Эхэд орсон дараах өгүүлбэр ямар хувиргалаар илэрснийг тодорхойлоорой.
 "Эмээ бурхан боллоо
 Буурал бүүвэйн эгшиг тасарч
 Буруу хагавчинд өрхний оосор ээдрэв"
 А. Хураах В. Салаалах С. Дэлгэрүүлэх
 D. Тонгоргох E. Ижилсүүлэх
24. Найруулгын алдаатай өгүүлбэрийг олоорой.
 А. Үнэнийг хүндлэх нь төгс билгийн эх сурвалж
 В. Тайхар чулуу тэнгэрээс ургаагүй, газраас унаагүй
 С. Эрх тэгш байхын анхдагч үзүүлэлт нь шударга ёс
 D. Үг нь үйл хэргийн сүүдэр
 E. Зэр зэвсэг хангинаж байх цагт хууль ёс амаа хамхидаг
25. Онцолсон үгийг хэлцээр солин найруулбал аль нь тохирох вэ?
 "Адуугаа олчхож ... гэж санаандгүй **цээжний бангаар** хэлчихлээ"
 А. Цаасан малгай өмсүүл- В. Молиго үмхүүл- С. Улайм цайм
 D. Ичих нүүргүй E. Цэнэггүй авах
26. Дараах үгсийн аймгийг жишээтэй нь зөв харгалзуулсан хэсгийг олоорой.
 1. Буурал, гэнэн, халуун, нойтон a. Төлөөлөх үгс
 2. Харуусал, тэвх, хурууд b. Тооны нэр
 3. Долоон долоо, хоёр, дөчин ес c. Жинхэнэ нэр
 4. Энэ, яагаа ч, миний d. Тэмдэг нэр
 А. 1a, 2b, 3c, 4e В. 1c, 2b, 3a, 4d С. 1b, 2a, 3c, 4d
 D. 1c, 2a, 3b, 4d E. 1d, 2c, 3b, 4a
27. Дараах хэлзүйн тайлбарт тохирох үгийг олоорой.
 /Ерийн, үүсмэл, ганц тоот, харьяалахын тийн ялгалд байгаа жинхэнэ нэр/
 А. Морины В. Дурдатгалын С. Эрдэнийн D. Хорвоогийн E. Хуурын
28. Дараах үгсийн утга, бүтцийг ажиглаад бусдаасаа өвөрмөц үгийг олоорой.
 А. Нуран В. Согтон С. Тэвхэн D. Асан E. Татан
29. Харьяалахын тийн ялгалын нөхцөлийн утгыг жишээтэй нь зөв харгалзуулсан хэсгийг олоорой.
 1. Эзний a. Морины толгой
 2. Хамаарал харьяаны b. Намрын нуур
 3. Бүхэл хэсгийн c. Эгчийн алчуур
 4. Цаг хугацааны d. Хуурын боолт
 А. 1d, 2c, 3a, 4b В. 1b, 2c, 3a, 4d С. 1a, 2b, 3c, 4d
 D. 1c, 2b, 3a, 4d E. 1b, 2a, 3d, 4c
30. Дараах холбоо үгсийг ажиглаад, үндсэн (шууд) утгаараа байгаа үгийг олоорой.
 А. Ханын толгой В. Шүдэнзний толгой С. Сонины толгой
 D. Морины толгой E. Цагаан толгой

31. Хүснэгт доторх өгүүлбэрийг уншаад аман зохиолын ямар төрөл зүйл болохыг тодорхойлоорой.

- | | | | | | |
|--|----|----|----|----|----|
| | A. | B. | C. | D. | E. |
| | | | | | |

32. “Хүлэг дээс” гэсэн холбоо үгийн “хүлэг” гэсэн үгийг зөв бичсэнийг олоорой.

- | | | | | |
|----|----|----|----|----|
| A. | B. | C. | D. | E. |
| | | | | |

33. “” гэсэн үгэнд бүгд тохирох нөхцөлтэй хэсгийг олоорой.

- | | | | | |
|----|----|----|----|----|
| A. | B. | C. | D. | E. |
| | | | | |

34. Бүх үг нь холбох эгшгийн дүрмээр бичигдсэн хэсгийг олоорой.

- | | | | | |
|----|----|----|----|----|
| A. | B. | C. | D. | E. |
| | | | | |

35. “Монголын нууц товчоо” зохиолын нэгдүгээр бүлэгт Есүхэй баатар Мэргидийн Их Чилэдүгээс Өэлүнийг булаан авахад Өэлүн Онон мөрнийг долгилтол, ой шугуйг ганхтал их дуугаар уйлдаг. Энэ үед :

- “Тэврэх хайрт эр чинь
Тэртээ даваа давав.
Уйлан санах эр чинь
Улс олныг гэтлэв” хэмээн хэн өгүүлсэн бэ?
- A. Есүхэй B. Нэгүүн тайж C. Даридай отчигин
D. Хадаан тайж E. Хутула

36. “Убаши хунтайжийн тууж” зохиолын гол үзэл санаа юу вэ?

- A. Ойрдын ноёдын харгис хэрцгий, дайнч байдлыг шүүмжилсэн
B. Халхын ноёдын харгис хэрцгий, дайнч байдлыг шүүмжилсэн
C. Ард түмний энх амгалан, эв нэгдлийн хүслэнг илэрхийлсэн
D. Халх, Ойрдын ноёдын эв нэгдлийг бататгах тэмцлийг дэмжсэн
E. Халх, Ойрдын ноёдын хагарлыг дэмжсэн

37. Д.Пүрэвдорж “Хөх даалимбан тэрлэг” найраглалдаа “Эр цэргийн эхнэр гэдэг эмэгтэйн төдий нэрийг хэлдэггүй. Хортон дайсны сум онодоггүй хоёр амины нэгийг хэлдэг юм” хэмээн товойлгон дүрсэлсний учир юу вэ?

- A. Эх орноо хамгаалахад эрэгтэй, эмэгтэй хүний үүрэг адилхан гэдгийг харуулах
B. Эр нөхрөө дайнд үдсэн эмэгтэйн үүрэг хариуцлага нэмэгддэг гэдгийг харуулах
C. Залуу хосын хайрын сэтгэлд дайны учруулсан харамсал, гашуудлыг харуулах
D. Дайнд явсан эр нөхөртөө дээл хийж байгаа эмэгтэйн байр байдлыг харуулах
E. Дайнаас амьд эргэж ирсэн эр нөхрөөрөө бахархаж байгаа эмэгтэйд харуулах

38. Зэрэгцүүлэн холбохын “-ж” нөхцөл залгахад аль үг нь бусдаасаа ялгаатай бичигдэх вэ?
А. Цохь В. Тавь С. Ярь D. Халь E. Хорь
39. Алдаатай бичсэн үгийг ол.
А. Судлалын В. Хөдлөлийн С. Ачлалын D. Аялалын E. Эдлэлийн
40. Зөв бичсэн үгийг ол.
А. Явчихаарай В. Харчихаад С. Хэлчихээрэй D. Олчихоод E. Бодчихоорой

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж:

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1. Чөлөөт бус холбоо үгийн хэв шинжийг тохирох жишээтэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|------------|--------------------------------|
| 1. ХЗ + УЗ | A. Нэг мөчийн үнэ цэнэ |
| 2. ҮС + ХЗ | B. Энэ дуугаа дуулан дуулсаар |
| 3. БЗ + ҮС | C. Олны дунд биеэ барих |
| 4. УЗ + ҮС | D. Тэнгэрийн заадсыг харж байн |
| 5. БЗ + ХЗ | E. Алтан тариа найган ганхана |

2.2. Хэлцүүдийг ойролцоо утгаар нь зөв харгалзуулаарай.

- | | |
|---|---|
| 1. Эрхийг сурахаар бэрхийг сур | A. Цочсон нохой цохноос айх |
| 2. Бардам ам, шалдан гуя | B. Нармайгүй ч гэсэн намбатай нь дээр |
| 3. Тэнэг хүн дуугүйдээ сүртэй | C. Арслан шиг архираад зурам шиг зугтах |
| 4. Өөрөө хожгор байж хүний халзныг гайхах | D. Дэрээ элээхээр дэвсээ элээ |
| 5. Айсан хүнд алсын уул хөдөлнө | E. Өмдгүй байж өвдөг цоорхойг шоолох |

2.3. Найруулгын төрлийг жишээтэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|---------------------------------|---|
| 1. Уран зохиолын найруулга | A. Ясны хатуулаг нь тоосгоноос 30 дахин ба боржин чулуунаас 2,5 дахин их байдаг. |
| 2. Албан бичгийн найруулга | B. Би хийсэн ч юмгүй шив дээ. Намар хэдэн хоног тарианд хөөгдөөд. |
| 3. Сонин нийтлэлийн найруулга | C. Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. |
| 4. Эрдэм шинжилгээний найруулга | D. Өнөөдөр Улаанбаатар хотод +20 хэм дулаан, багавтар үүлтэй байна. |
| 5. Ярианы найруулга | E. Тугал тугал тоглоно
Туул голдоо очно |

2.4. Дараах зохиолын нэрсийг ишлэлтэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|--|--|
| 1. Очирын шунахай сэтгэл улам хөгжиж хээр мориндоо унасан хүнийг булгиж хаях ба цулбуураа тасдаж уяанаас зугтах зэрэг муу зан сургажээ. | A. С.Эрдэнэ “Хулан бид хоёр” |
| 2. Долдугаар сарын нэгэн өдөр би нутгийнхаа Чингис хаан болоод түүний залуу гэргийн хамт сумынхаа наадамд очихоор эртлэн мордлоо. Тэр Чингис хаан гэдэг маань ердөө л шар Цамба юм шүү дээ. | B. П.Пүрэвсүрэн “Өшөө” |
| 3. Манаач өвгөн орой манаанд гарах бүр үнэртэй усны нэг бяцхан хавтгай дугуй шилэнд архи хийж өвөртлөөд, өвөл бол дах, зун бол цуваа хэдрээд, муу бярдан буугаа барин дэлгүүрийн үүдэнд байдаг модон вандан сандал дээр суугаад... | C. Ц.Дамдинсүрэн “Өлзийтийн хээр” |
| 4. Уран тачаангуйн хурц илдийг боловсруулахын эрдмийг судалсан хүүхэн Иүй Бай-Хуа... | D. Б.Ринчен “Мангаа Доогийн эцсийн зүүд” |
| 5. Дорж хойд Шээзгийт дээр дурандаж суутал Дорги чоноо хөтөлсөөр Шээзгийтийн шандан дээр ирэх нь харагджээ. | E. Д.Нацагдорж “Ламбагуайн нулимс” |

ХУВИЛБАР В

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж:

1. Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгавруудыг гүйцэтгээрэй.
2. Эхээс сонгож авсан өгүүлбэр, үгсийг эхтэй нь холбон уншиж ажиглаарай.
3. Сонгох даалгавруудын зөвхөн нэгийг сонгоорой. (Даалгавар бүр 2 оноотой.)

Нутгийн айраг

Ах маань энэ жил бас л ирж над нэг хөхүүр айраг авчрав. Ээжийн явуулсан хөхүүрэнд аавын адуу багтаад ирсэн мэт санагдана. Цээлийн нууранд олон адуу шаагин ороход Хангайн булагаас зорьж ирээд амарч амжаагүй лам шувуунууд усаа харамлах мэт орь дуу тавин нисч, адуун дээгүүр хэдэнтээ өнгөрөхүй усны захад хулган зогссон хэнз халтар унага тэдний сүүдрээс цочин давхийж, түүнийгээ булзааруулахын тулд эргийн ногоон зүлгэн дээгүүр тонгочин давхина. Аагаа багтааж ядсан тарган байдаснууд нуурын гол руу их л лав ороход адууны зах барьдаг асман зээрд хойноос нь очмоор санагдавч хээр азарганаас баахан эмээнэ. Тэгээд хялалзан, “энэ муу хөгшин хээр норсон дэлээ даахгүй” гэж сэм бодовч ноднин жилийн хасуулсан хөндүүр гараагүй тул албаар ус цавчлан бодлоо сарниулж нүглийг умартана. Олон адуу уснаас шаагин гарч саамын зэл рүү цувахад саагнаас нь ус дуслан онгож байгаа өвсөнд адууны мөрөөр шүүдэр үлдэнэ. Сэлэнгийн шар намар, замын тоос, ажлын цуурай тэнгэрт хадаж ахын авчирч өгсөн хөхүүртэй айраг усанд орж байгаа адуу шиг шаагина.

(Ж. Лхагва)

1. Эхийн үйл явдлыг зөв дараалалд оруулсан хэсгийг дугуйлаарай.
 1. Асман зээрд хээр азарганаас баахан эмээнэ.
 2. Ээжийн явуулсан хөхүүрэнд аавын адуу багтаад ирсэн мэт санагдана.
 3. Ахын авчирч өгсөн хөхүүртэй айраг адуу шиг шаагина.
 4. Олон адуу уснаас шаагин гарна.
 5. Цээлийн нууранд олон адуу шаагин орно.

A. 2, 5, 1, 4, 3	B. 2, 5, 3, 1, 4	C. 2, 5, 4, 3, 1
D. 2, 5, 1, 3, 4	E. 2, 5, 4, 1, 3	
2. Дээрх эхийн жинхэнэ нэрийг утгаар нь зүйлчилбэл ямар утгын зүйлчлэл байхгүй байна вэ?

A. Хүний зүйл	B. Ургамлын зүйл	C. Хий үзэгдлийн зүйл
D. Сэтгэхүйн зүйл	E. Хүний бүтээсэн зүйл	
3. Дээрх эхийн хэв маягийг тодорхойлно уу.

A. Тоочимж	B. Эргэцүүлэмж	C. Тайлбарламж
D. Учирламж	E. Хүүрнэмж	
4. Дээрх эх найруулгын ямар төрлөөр бичигдсэн байна вэ?

A. Уран зохиолын найруулга	B. Албан бичгийн найруулга
C. Сонин нийтлэлийн найруулга	D. Ярианы найруулга
E. Эрдэм шинжилгээний найруулга	
5. Дээрх эхийн сэдвийг олоорой.

A. Нуур, усны тухай	B. Аав, ээжийн тухай	C. Айрагны тухай
D. Адууны тухай	E. Ажил, хөдөлмөрийн тухай	
6. Дээрх эхийн гол санааг илэрхийлсэн тулгуур өгүүлбэрийг олоорой.
 - A. Хэнз халтар унага эргийн ногоон зүлгэн дээгүүр тонгочин давхина.
 - B. Ахын авчирч өгсөн хөхүүртэй айраг усанд орж байгаа адуу шиг шаагина.
 - C. Нууранд адуу шаагин ороход лам шувуунууд усаа харамлах мэт орь дуу тавин ниснэ.
 - D. Ээжийн явуулсан хөхүүрэнд аавын адуу багтаад ирсэн мэт санагдана.
 - E. Асман зээрд байдаснуудын хойноос нь очмоор санагдавч хээр азарганаас баахан эмээнэ.
7. Дээрх эх хэдэн цогцолбороос бүтсэн байна вэ?
 - A. “Ах маань... ирсэн мэт санагдана”, “Цээлийн нууранд... нүглийг умартана”, “Олон адуу... шүүдэр үлдэнэ”, “Сэлэнгийн шар намар... адуу шиг шаагина” гэсэн 4 цогцолбор
 - B. “Ах маань...шүүдэр үлдэнэ”, “Сэлэнгийн шар намар... адуу шиг шаагина” гэсэн 2 цогцолбор
 - C. “Ах маань... ирсэн мэт санагдана”, “Цээлийн нууранд... шүүдэр үлдэнэ”, “Сэлэнгийн шар намар... адуу шиг шаагина” гэсэн 3 цогцолбор
 - D. 1 цогцолбороос бүтсэн бичил эх

- Е. “Ах маань... ирсэн мэт санагдана”, “Цээлийн нууранд... тонгочин давхина”, “Аагаа багтааж ядсан... нүглийг умартана”, “Олон адуу...шүүдэр үлдэнэ”, “Сэлэнгийн шар намар... адуу шиг шуугина” гэсэн 5 цогцолбор
8. Дээрх эхийн тулгуур үгсийг зөв бүлэглэсэн хэсгийг олоорой.
 А. Хөхүүр, айраг, лам шувуу, хэнз унага, адуу, шүүдэр
 В. Ах, хөхүүр, айраг, нуур, адуу, ус
 С. Ах, ээж, аав, айраг, адуу, ажил
 D. Хөхүүр айраг, Цээлийн нуур, Хангайн булаг, хөндүүр, бодол
 E. Халтар унага, байдас, асман зээрд, хөгшин хээр, хөхүүртэй айраг
9. Дараах өгүүлбэрээс шинэ санааг илэрхийлсэн дүрслэх ур маягийг тодорхойлоорой.
 “Ахын авчирч өгсөн хөхүүртэй айраг усанд орж байгаа адуу шиг шаагина”
 А. Зүйрлэл
 В. Төлөөлөл
 С. Ихэсгэл
 D. Адилтгал
 E. Тойруулал
10. Дараах тодорхойлолтын цэгийн оронд тохирох үгийг олоорой.
 Хэлний дүрслэх хэрэглүүрээр оновчтой, уран, шинэ дүр дүрслэл, содон санаа бүтээхийг эхийн гэнэ.
 А. Зорьсон санаа
 В. Төрсөн санаа
 С. Гол санаа
 D. Шинэ санаа
 E. Төгс санаа
11. Бүгд баймж, үнэлэмж, сэтгэл хөдлөлийн өнгө аяс илтгэсэн хэсгийг олоорой.
 А. ...ирсэн мэт, ...энэ муу, ...харамлах мэт, ...бас л ирж, ... их л лав, ...адуу шиг шаагина
 В. ...цочин давхийж, ...очмоор санагдавч, ... их л лав, ...энэ муу, ...баахан эмээнэ
 С. ...харамлах мэт, ...бас л ирж, ...ирсэн мэт, ... сэм бодовч, ...энэ муу, ...орь дуу тавих
 D. ...ирсэн мэт, ... сэм бодовч, ...орь дуу тавих, ... их л лав, ...энэ муу, ... тонгочин давхина
 E. ...очмоор санагдавч, ... сэм бодовч, ... орь дуу тавих, ...энэ муу, ...адуу шиг шаагина
12. Дараах өгүүлбэрүүдийн утгын харьцааг тодорхойлоорой.
 “Хумсын чинээхэн нар тонон дааганаас мултарч ядна. Өвөө тэр холоос сульдсан зүрхнээсээ дуугарна”
 А. Зүйлчилсэн
 В. Төсөөт
 С. Эсрэг
 D. Ойролцоо
 E. Ижил
13. Дараах өгүүлбэрийн баймж утгыг тодорхойлоорой.
 “Адуугаа олчхож гэж санаандгүй цээжний бангаар хэлчихлээ”
 А. Зайлшгүй баймж
 В. Бодит баймж
 С. Үнэн магадлалт
 D. Хэм хэмжээт баймж
 E. Бололцоот баймж
14. “Магнай тэнийх” гэсэн хэлцтэй эсрэг утгатай үг аль нь вэ?
 А. Санаашрах
 В. Гуйх
 С. Итгэх
 D. Санах
 E. Гомдох
15. Ойролцоо утгатай үг орсон хэлцийг ол.
 А. Бушуу туулай борвиндоо баастай
 В. Их нохой хуцахад, бага нохой дуурайдаг
 С. Дээсний ахар нь, үгийн богино нь дээр
 D. Хоёр идэхгүй, хоосон хонохгүй
 E. Өдрийн бодол, шөнийн зүүд
16. Дараах үгсийг уншаад, харь үгийг ол.
 А. Саван
 В. Жаргал
 С. Туулай
 D. Бөөрөнхий
 E. Сэлэнгэ
17. Дараах үгсээс дүрслэх язгуур бүхий хэсгийг олоорой.
 А. Цөмлөх, нэвтрэх, задрах, бяцлах
 В. Тарих, давтах, хөдөлмөрлөх, үйлдэх
 С. Суллах, нүдлэх, ганзагалах, хайрлах
 D. Хоржигнох, ганганах, тогших, цангинах
 E. Жингэнэх, годгонох, хурхирах, сандрах
18. Дараах үгийг бүтцээр зөв задалсныг олоорой.
 А. Ангир + 0 + 0 + аа
 В. Ангир + 0 + аа
 С. Анги + р + аа
 D. Ангир + аа
 E. Ангир + аа + 0
19. Дараах өгүүлбэрийн шинжид тохирох тодорхойлолтыг олоорой.
 “Адуугаа олоо болов уу?”
 А. Энгийн, анхааруулах, гурван бүрэлдэхүүнт, цөм өгүүлбэр
 В. Энгийн, асуух, гурван бүрэлдэхүүнт, цөм өгүүлбэр
 С. Энгийн, асуух, хоёр бүрэлдэхүүнт, цөм өгүүлбэр
 D. Энгийн, хүүрнэх, хоёр бүрэлдэхүүнт, цөм бус өгүүлбэр
 E. Энгийн, захирах, гурван бүрэлдэхүүнт, цөм өгүүлбэр
20. Дараах өгүүлбэрийн бүтцийг тодорхойлоорой.
 “Адуу тургилахыг сонсох юмсан...гээд хэлсэн үгэндээ хахах мэт дуугүй болов”
 А. Угсарсан нийлмэл өгүүлбэр
 В. Харилцан угсарсан нийлмэл өгүүлбэр
 С. Холимог нийлмэл өгүүлбэр
 D. Энгийн, нэрлэсэн өгүүлбэр
 E. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр

21. Нэрийн холбоо үг бүхий хэсгийг олоорой.
 А. Өмсч гар-, сульдсан зүрх, хумсын чинээ В. Мултарч яд-, тод дуулд-,гүнгэнэн үүрс-
 С. Баруун хагавч, дөрөө дуугар-, бүтээсэн өрх D. Хүнд зовхи, тоононы даага, амьсгал тат-
 E. Хүнд зовхи, сумын эмч, цагаан нөмрөг
22. Дараах өгүүлбэрийн онцолсон үг ямар гишүүн болох вэ?
 “Ашгүй уяан дээр дөрөө дуугарч, **адуу** гүнгэнэн үүрсэв”
 А. Өгүүлэгдэхүүн В. Өгүүлэхүүн С. Шууд бус тусагдахуун
 D. Шууд тусагдахуун E. Байц
23. Эхэд орсон дараах өгүүлбэр ямар хувиргалаар илэрснийг тодорхойлоорой.
 “Тийм байна аа”
 А. Хураах В. Дэлгэрүүлэх С. Салаалах
 D. Тонгоргох E. Ижилсүүлэх
24. Найруулгын алдаатай өгүүлбэрийг олоорой.
 А. Амьдралын мөн чанар бол мөнхийн урсгал.
 В. Хүн магтаалд боолгон, мартахуйд шингэдэг.
 С. Хувь заяа оньсого мэт, нэр алдар хуурамч болой.
 D. Марташгүй хань нөхөрт хагацашгүй муу үгийг бүү өгүүл.
 E. Хүмүүс бие биенийхээ тулд л амьд явдаг.
25. Онцолсон хэлц өгүүлбэрийг утгаар нь солин найруулбал аль нь тохирох вэ?
 “Товьчуул хуурын нүдэнд **гуниг унагахгүй** гэж ингэж гашууддаг заншилтай”
 А. Цээж тэний- В. Хийморь доройт- С. Сүүдэр унага-
 D. Урам хугар- E. Сэтгэлээр унага-
26. Дараах үгсийн аймгийг жишээтэй нь зөв харгалзуулсан хэсгийг олоорой.
 1. Нэг, дөчин ес, сар гаруй а. Төлөөлөх үгс
 2. Би, ямар, хэдэн, нөгөө б. Тооны нэр
 3. Гоё, нандин, улаан, дүүрэн с. Орон цагийн нэр
 4. Зүүн, хойш, дээгүүр d. Тэмдэг нэр
 А. 1a, 2b, 3c, 4e В. 1c, 2b, 3a, 4d С. 1b, 2a, 3d, 4c
 D. 1c, 2a, 3b, 4d E. 1d, 2c, 3b, 4a
27. Эхээс дараах хэлзүйн тайлбарт тохирох үгийг олоорой.
 /Ерийн, үүсмэл, ганц тоот, заахын тийн ялгалд байгаа жинхэнэ нэр/
 А. Гунигаа В. Ногооныг С. Хуурыг D. Дуугаа E. Уруулаа
28. Дараах үгсийн утга, бүтцийг ажиглаад бусдаасаа өвөрмөц үгийг олоорой.
 А. Байршил В. Заншил С. Түншил D. Ууршил E. Гаршил
29. Харьяалахын тийн ялгалын нөхцөлийн утгыг жишээтэй нь зөв харгалзуулсан хэсгийг олоорой.
 1. Орны а. Гэрийн хоймор
 2. Зориулалтын б. Хуурын толгой
 3. Бүхэл хэсгийн с. Эгчийн алчуур
 4. Эзний d. Нүдний шил
 А. 1d, 2c, 3a, 4b В. 1b, 2c, 3a, 4d С. 1a, 2d, 3b, 4c
 D. 1c, 2d, 3a, 4b E. 1b, 2a, 3d, 4c
30. Дараах холбоо үгсийг ажиглаад, үндсэн (шууд) утгаараа байгаа үгийг олоорой.
 А. Нүд алд- В. Нүд унага- С. Нүд хуур- D. Нүд чил- E. Нүд булаа-
31. Хүснэгт доторх өгүүлбэрийг уншаад аман зохиолын ямар төрөл зүйл болохыг тодорхойлоорой.

سَمْعَن وَهِنَا حَرِ جَوَشِنَبَا

سَمْعِنَرِ يَمَعِن حَرِ جَوَشِنَبَا

A. سَمْعِنَبَا






B. سَمْعِنَمَبَا

C. سَمْعِنَبَا حَرِ جَوَشِنَبَا


























D. سَمْعِنَبَا حَرِ جَوَشِنَبَا

E. سَمْعِنَبَا حَرِ جَوَشِنَبَا











32. “Санхүү” гэсэн холбоо үгийн “хүү” гэсэн үгийг зөв бичсэнийг олоорой.

- A.  B.  C.  D.  E. 

33. “” гэсэн үгэнд бүгд тохирох нөхцөлтэй хэсгийг олоорой.

- A.  · 
 · 

- B.  · 
 · 

- C.  · 
 · 

- D.  · 
 · 

- E.  · 
 · 


34. Бүх үг нь холбох эгшгийн дүрмээр бичигдсэн хэсгийг олоорой.

- A.  
- B.  
- C.  
- D.  
- E.  

35. “Монголын нууц товчоо” зохиолын нэгдүгээр бүлэгт Есүхэй баатар Татарт хорлогдон арай ядан гэрт хүрч “Миний дотор муу байна... Тэмүүжин хөвгүүнийг даруй авчир” гэхэд дэргэд нь хэн байсан бэ?

- A. Чирха B. Бэлгүтэй C. Даридай отчигин D. Дэй Сэцэн E. Мэнлиг

36. “Хув Нагваралын тууж” зохиолын гол үзэл санаа юу вэ?

- A. Ард түмний энх амгалан, эв нэгдлийн хүслэнг илэрхийлсэн
 B. Халх, Ойрдын ноёдын хагарлыг дэмжсэн
 C. Ойрдын ноёдын харгис хэрцгий, дайнч байдлыг шүүмжилсэн
 D. Халх, Ойрдын ноёдын эв нэгдлийг бататгах тэмцлийг дэмжсэн
 E. Халхын ноёдын харгис хэрцгий, дайнч байдлыг шүүмжилсэн

37. Ц.Дамдинсүрэн гуай “Чемодантай юм” өгүүллэгтээ Цээмаа, Бумаа хоёрын уулзан ярилцаж байгаа хэсэгт нэгэн хогийн савны тухай дүрсэлсэн байдаг. Энэ нь юуг харуулсан хэрэг вэ?

- A. Тэдний уулзаж байгаа газрын бохир байдлыг
 B. Хүний гадаад байдал, дотоод сэтгэл хоёрын ялгааг
 C. Нар жаргаж байгааг тод томруун харуулахын тулд
 D. Цээмаагийн шуналтай занг хогийн савтай зүйрлэхийн тулд
 E. Тэр хоёрт ярианы сэдэв гаргахын тулд

38. Зэрэгцүүлэн холбохын “-ж” нөхцөл залгахад аль үг нь бусдаасаа ялгаатай бичигдэх вэ?

- A. Сорь B. Гунь C. Уль D. Захь E. Хунь

39. Алдаатай бичсэн үгийг ол.

- A. Малла B. Тосло C. Төлөвлө - D. Сумла E. Нэрлэ

40. Зөв бичсэн үгийг ол.

- A. Уяъя B. Бодоё C. Сурья D. Хэлэе E. Харая

ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Чөлөөт бус холбоо үгийн хэв шинжийг тохирох жишээтэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|------------|-----------------------------|
| 1. ҮС + БЗ | A. Ам алдвал барьж болдогүй |
| 2. ҮС + ХЗ | B. Манан хүдэнт уулсын орой |
| 3. БЗ + ҮС | C. Нам гүмхэн нэгэн үдэш |
| 4. УЗ + ХЗ | D. Нэг гэрт толгой холбох |
| 5. БЗ + УЗ | E. Төв аймгийн засаг дарга |

2.2. Хэлцүүдийг ойролцоо утгаар нь зөв харгалзуулаарай.

- | | |
|-------------------------------------|--|
| 1. Өлөн гэдэс өвчүүтэй наалдах | A. Сүүнд халсан хүн тараг үлээх |
| 2. Үнээ үхэхдээ сүү оров | B. Дотор газраас өр нэхэх |
| 3. Хэрээ хэрээнийхээ харыг гайхав | C. Гар бариад бугуй барих |
| 4. Сандрахдаа сар өөд самардах | D. Ниргэсэн хойно нь хашхирах |
| 5. Амгашсан хэрээ арван гурав эргэх | E. Эргүү шулга хоёр бие биеэ хэлэв гэх шиг |

2.3. Найруулгын төрлийг жишээтэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|---------------------------------|---|
| 1. Уран зохиолын найруулга | A. Монгол Улсын Ерөнхий сайд хуулийн төсөл өргөн барилаа. |
| 2. Албан бичгийн найруулга | B. Монгол таргийн хөрөнгийн микрофлор, амт, чанар Болгар тарагтай ихээхэн ойролцоо байна. |
| 3. Сонин нийтлэлийн найруулга | C. Мужаан З.Доржийн ажилласан хоногийн хөлсийг тооцон олгохыг ня-бо Ж. Алтанд зөвшөөрсүгэй. |
| 4. Эрдэм шинжилгээний найруулга | D. Ажил нь жаахан хэцүү юм аа. За уулзана аа хоёулаа. |
| 5. Ярианы найруулга | E. Хөндий талын зэрэглээ мяралзан жирлэх нь холоос үзэхэд сонин. |

2.4 Дараах зохиолын нэрсийг ишлэлтэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|---|---|
| 1. Зуны цагт баруун дамнуурчны таван гудамжны шавар үлэмж, үнэр ханхлах нь үнэхээр таван багц хүжийг шатаавч үл дарагдмаар. | A. С.Эрдэнэ “Малын хөлийн тоос” |
| 2. “Хун галуу, нагал хавч, хурын үүл, хурмастын хишиг, ясны хайртай Янжин, янагийн хайртай Чанцал. Татлаа, татуулах уу” | B. П.Пүрэвсүрэн “Өшөө” |
| 3. Их мөрний хөвөөнд үнэт эрдэнэ гээчээд эрж яваа юм шиг урагш хойш тонголзон холхих нэгэн хүний хэлбэр төрхийг алсаас харахад нар шингэх үеийн хайлаас модны сүүдэр шиг тахир агаад нэн өндөр. | C. Д.Нацагдорж “Ламбагуайн нулимс” |
| 4. Энэ үед Дорж гуайг харахад их үер юм уу, салхинд хэсэг мөчрөө хугалуулсан боловч ялж гараад навч дэлгэн байгаа бүдүүн улиас шиг байв. | D. Д.Мягмар “Үер” |
| 5. Энэ хойд хадат ааргийг дээр үед Шээзгий толгод гэдэг байсан юм. Нээрэн ч холоос харахад чандмалан хөмөрсөн гурван шээзгий шиг харагддаг юм л даа. | E. Ч.Лодойдамба “Хугараагүй ноён нуруу” |

ХУВИЛБАР С

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж:

1. Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгавруудыг гүйцэтгээрэй.
2. Эхээс сонгож авсан өгүүлбэр, үгсийг эхтэй нь холбон уншиж ажиглаарай.
3. Сонгох даалгавруудын зөвхөн нэгийг сонгоорой. (Даалгавар бүр 2 оноотой)

Шаргачин

Буу зогсолтгүй шахам нижгэнэж, машины дохио чимээ үргэлжлэн дуугарч, шаргачны үсрэх цойлох нь ховордон, цэлмэг нүд нь бүлтгэнэн манантаж, босоо чих нь алгуураар хойшоо бууж байлаа. Машин дотроос “Хар барам чинь оногдохгүй нь. Ёо, ёо, ямар их донсолдог юм бэ? Толгой хагалчих нь. Аль вэ сум аваад аль! Өмнө нь барьж байгаад мулталж орхи. Аа, мондиос чинь болж гараа шалбалж орхилоо. Чамайг уу даа!” гэх зэрэг дуу сонстож байлаа. Гагцхүү жолоочийн ард хөдлөлгүй суугаад хөмхийгөө зуун, салхинд бага зэрэг гандсан нүүрээ барайлган, барьж ядсан заналхийлэл нүдэнд нь туяарсан нэг хүн үг дуугаралгүй “Толгойгоо цохих, гараа шалбалах чинь юу ч биш. Харин гэмгүй амьтны амьдралаар хууль зөрчиж тоглон эрхлэх чинь дэндэж байна”

Боловсролын Үнэлгээний Төв

гэж сэтгэлдээ дахин дахин шивэгнэн явжээ. Үнэндээ, хөөгчдөд энэ явдал богино хугацааны хөгжилтэй тохиол байсан бол шаргачинд хоёр амийн төлөө хийж байгаа ширүүн тэмцэл байжээ.












(Ч.Лодойдамба)

1. Эхийн үйл явдлыг зөв дараалалд оруулсан хэсгийг олоорой. (2 оноо)
 1. Аа, мондиос чинь болж гараа шалбалж орхилоо.
 2. Хоёр амийн төлөө хийж байгаа ширүүн тэмцэл байжээ.
 3. Харин гэмгүй амьтны амьдралаар хууль зөрчиж тоглон эрхлэх чинь дэндэж байна.
 4. Толгойгоо цохих, гараа шалбалах чинь юу ч биш.
 5. Шаргачны үсрэх цойлох нь ховордон...
 - A. 5, 1, 3, 4, 2
 - B. 5, 1, 4, 2, 3
 - C. 5, 4, 1, 3, 2
 - D. 5, 2, 4, 3, 1
 - E. 5, 1, 4, 3, 2
2. Дээрх эхийн жинхэнэ нэрийг утгаар нь зүйлчилбэл ямар утгын зүйлчлэл байхгүй байна вэ? (2 оноо)
 - A. Хүний зүйл
 - B. Амьтны зүйл
 - C. Гариг эрхсийн зүйл
 - D. Ургамлын зүйл
 - E. Хүний бүтээсэн зүйл
3. Дээрх эхийн хэв маягийг тодорхойлно уу. (2 оноо)
 - A. Хүүрнэмж
 - B. Тоочимж
 - C. Эргэцүүлэмж
 - D. Тайлбарламж
 - E. Учирламж
4. Дээрх эх найруулгын ямар төрлөөр бичигдсэн байна вэ? (2 оноо)
 - A. Албан бичгийн найруулга
 - B. Эрдэм шинжилгээний найруулга
 - C. Уран зохиолын найруулга
 - D. Сонин нийтлэлийн найруулга
 - E. Ярианы найруулга
5. Дээрх эхийн сэдвийг олоорой. (2 оноо)
 - A. Шаргачны тухай
 - B. Харгис зангийн тухай
 - C. Амьдралын тэмцлийн тухай
 - D. Байгаль хамгааллын тухай
 - E. Хүн, байгалийн хүйн холбоо
6. Дээрх эхийн гол санааг илэрхийлсэн тулгуур өгүүлбэрийг олоорой. (2 оноо)
 - A. Шаргачны үсрэх цойлох нь ховордон, цэлмэг нүд нь бүлтгэнэн манантаж, босоо чих нь алгуураар хойшоо бууж байлаа.
 - B. Толгойгоо цохих, гараа шалбалах чинь юу ч биш.
 - C. Гэмгүй амьтны амьдралаар хууль зөрчиж тоглон эрхлэх чинь дэндэж байна.
 - D. Шаргачинд хоёр амийн төлөө хийж байгаа ширүүн тэмцэл байжээ.
 - E. Хөөгчдөд энэ явдал богино хугацааны хөгжилтэй тохиол байсан.
7. Дээрх эх хэдэн цогцолбороос бүтсэн бэ? (2 оноо)
 - A. “Буу... бууж байлаа”, “Машин дотроос ... сонстож байлаа”, “Гагцхүү...дуугаралгүй”, “Толгойгоо цохих...шивэгнэн явжээ”, “Үнэндээ.. тэмцэл байжээ” гэсэн 5 цогцолбор
 - B. “Буу... бууж байлаа”, “Машин дотроос ... сонстож байлаа”, “Гагцхүү... шивэгнэн явжээ”, “Үнэндээ ... тэмцэл байжээ” гэсэн 4 цогцолбор
 - C. “Буу... сонстож байлаа”, “Гагцхүү... шивэгнэн явжээ”, “Үнэндээ ... тэмцэл байжээ” гэсэн 3 цогцолбор
 - D. “Буу... сонстож байлаа”, “Гагцхүү... тэмцэл байжээ” гэсэн 2 цогцолбор
 - E. 1 цогцолбороос бүтсэн бичил эх
8. Дээрх эхийн тулгуур үгсийг зөв бүлэглэсэн хэсгийг олоорой. (2 оноо)
 - A. Шаргачин, буу, машин, толгой, гар, тэмцэл, нэг хүн, дуу
 - B. Шаргачин, дохио чимээ, буу, дуу, машин, монди, тэмцэл, нүд
 - C. Шаргачин, хөөгчид, жолооч, буу, дуу, машин, тэмцэл, нүд
 - D. Шаргачин, буу, дуу, толгой, гар, хууль, тэмцэл, чих
 - E. Шаргачин, чих, нүд, хөмхий, нүүр, дуу, тэмцэл, хууль
9. Дараах өгүүлбэрээс шинэ санаа илэрхийлсэн дүрслэх ур маягийг тодорхойлоорой. “Үнэндээ, хөөгчдөд энэ явдал богино хугацааны хөгжилтэй тохиол байсан бол шаргачинд хоёр амийн төлөө хийж байгаа ширүүн тэмцэл байжээ”
 - A. Адилтгал
 - B. Ихэсгэл
 - C. Төлөөлөл
 - D. Тойруулал
 - E. Хүншүүлэл
10. Дараах тодорхойлолтын цэгийн оронд тохирох үгийг олоорой. (2 оноо)

Зохиолын төрсөн санааг гол үйл явдлаар дүрсэлж, дүгнэлт гаргахыг эхийнгэнэ.

 - A. Төрсөн санаа
 - B. Гол санаа
 - C. Зорьсон санаа
 - D. Шинэ санаа
 - E. Төгс санаа

11. Бүгд баймж, үнэлэмж, сэтгэл хөдлөлийн өнгө аяс илтгэсэн хэсгийг олоорой. (2 оноо)
 А. ...Хар барам чинь, ...зогсолтгүй шахам, ...мулталж орхи, ...хөгжилтэй тохиол
 В. ...мондиос чинь болж, ...оногдохгүй нь, ...цэлмэг нүд, ...бууж байлаа
 С. ...эрхлэх чинь л, ...дахин дахин, ...ямар их, ...толгойгоо цохих
 Д. ...Үнэндээ, ...ёо, ёо, ...аваад аль!, ...шивэгнэн явжээ
 Е. ...ямар их донсолдог юм бэ?, ...чамайг уу даа!, ...шалбалах чинь юу ч биш, ...үнэндээ
12. Дараах үгсийн аль нь бүхэлзүйжсэн холбоо үг вэ? (2 оноо)
 А. Машин дотроос В. Энэ явдал С. Мулталж орхи
 Д. Үсрэх цойлох Е. Толгойгоо цохих
13. “Бороотой өдөр л сэтгэл **хүнд**” гэхэд онцлон зурсан үг өгүүлбэрт ямар гишүүн болох вэ? (2 оноо)
 А. Өгүүлэгдэхүүн В. Өгүүлэхүүн С. Тодотгол
 Д. Байц Е. Тусагдахуун
14. “Тэвч өдөр бүр бороо ордоггүй шүү дээ” гэсэн өгүүлбэр хэлэх зорилго, аялгаараа ямар өгүүлбэр вэ? (2 оноо)
 А. Асуух өгүүлбэр В. Анхааруулах өгүүлбэр С. Захирах өгүүлбэр
 Д. Хүүрнэх өгүүлбэр Е. Батлах өгүүлбэр
15. “...ханатлаа уйлсны дараа дотор онгойх шиг тэнгэрийн хаяа нь цэлийн ирэхүй” гэхэд ямар дүрслэх ур маяг /хэрэглүүр/ ашигласан байна вэ? (2 оноо)
 А. Адилтгал В. Зүйрлэл С. Ихэсгэл
 Д. Төлөөлөл Е. Тойруулал
16. “Ухаан далай номоос эхтэй Усан далай булгаас эхтэй” гэсэн хэлний нэгжүүд утгын ямар харьцаанд байна вэ? (2 оноо)
 А. Ойролцоо утгын В. Эсрэг утгын С. Төсөө утгын
 Д. Зүйлчилсэн утгын Е. Өвөрмөц хэлцийн
17. “Түүнтэй арван зургаа долоо орчим насны хүү нэлээд гундаж шарлангитсан мөртөө амаа гүйцэд мэдээгүй омголон хул үрээ унаж явна” гэсэн өгүүлбэрийн **хүү - морь** гэсэн үйлдэгчийн харьцааг зөв тодорхойлсныг олоорой. (2 оноо)
 А. Эрхэн ба сөрөн үйлдэгч В. Эрхэн ба хэрэглэн үйлдэгч С. Эрхэн ба өртөн үйлдэгч
 Д. Эрхэн ба бүтээн үйлдэгч Е. Эрхэн ба эдлэн үйлдэгч
18. “Түүнтэй арван зургаа долоо орчим насны хүү нэлээд гундаж шарлангитсан мөртөө амаа гүйцэд мэдээгүй омголон хул үрээ унаж явна” гэсэн өгүүлбэрт дүрслэгдэж буй морь нь ... (2 оноо)
 А. Номхон адуу В. Хашин адуу С. Хурдан адуу
 Д. Сайн адуу Е. Дошгин адуу
19. Дараах өгүүлбэрийн шинжид тохирох тодорхойлолтыг олоорой. (2 оноо)
 “Намрын нуур ангираа гөвлөө”
 А. Энгийн, хүүрнэх, гурван бүрэлдэхүүнт, цөм өгүүлбэр
 В. Энгийн, хүүрнэх, гурван бүрэлдэхүүнт, цөм бус өгүүлбэр
 С. Энгийн, хүүрнэх, хоёр бүрэлдэхүүнт, цөм өгүүлбэр
 Д. Энгийн, хүүрнэх, хоёр бүрэлдэхүүнт, цөм бус өгүүлбэр
 Е. Энгийн, захирах, гурван бүрэлдэхүүнт, цөм өгүүлбэр
20. Аливаа өгүүлбэрийг эсрэг утга санаагаар хувиргаж бичвэл: (2 оноо)
 А. Салаалсан өгүүлбэр бүтнэ В. Тонгоргосон өгүүлбэр бүтнэ
 С. Хураангуйлсан өгүүлбэр бүтнэ Д. Дэлгэрүүлсэн өгүүлбэр бүтнэ
 Е. Нийлмэл өгүүлбэр бүтнэ
21. “Хэрлэнгийн хойд уулс цэнхэр хүдэнд дуниартаж Гүн галуут нуур, Нүүрэнгийн тал, Байдрагийн хавь уужим хөндий, мөн тэр хөндий рүү умраас хатган орсон ухаа гүвээнүүд зуны цэлмэг тэнгэртэй найрсан, хөх ногоон туяа татаж, газар дэлхий дээр амьтай төрсөн бүхэн жарган цэнгүүштэй” гэсэн өгүүлбэрийн баймж үнэлэмжийг тайлбарла. (2 оноо)
 А. Үйл байдлын уйтгар гунигтайг илэрхийлжээ
 В. Үйл байдлын баяр бахдалтайг илэрхийлжээ
 С. Үйл байдлын дуу хууртайг илэрхийлжээ
 Д. Үйл байдлыг сэтгэлд зохистойг илэрхийлжээ
 Е. Үйл байдлын хөөр хөгжөөнтэйг илэрхийлжээ
22. “Төвд хоргой эмжээр, саарал чисчүү дээл” гэдэгтэй адил утга бүтэц бүхий хэсгийг олоорой. (2 оноо)
 А. Зузаан даавуун цамц, хар үнэгэн малгай
 В. Хятад торгон цамц, хэлхгэр ямбуу өмд
 С. Ногоон торгон дээл, ногоон пийсүү соруул
 Д. Орос хийцийн хувцас, хар ишгэн дээл
 Е. Энэтхэг даавуун палааж, улаан пансан алчуур

23. Дараах өгүүлбэрийн бүтцийг тодорхойлоорой. (2 оноо)
 “Хаяхад хайран, Хадгалахад хэцүү”
 А. Угсарсан нийлмэл өгүүлбэр В. Харилцан угсарсан нийлмэл өгүүлбэр
 С. Холимог нийлмэл өгүүлбэр D. Энгийн, хэлзүйжсэн өгүүлбэр
 Е. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр
24. Бүгд жинхэнэ нэр байгаа хэсгийг олоорой. (2 оноо)
 А. Цаадах, наадах, хажуудах, дээдэх, дэргэдэх В. Харх, бурхи, дархи, салхи, тэх
 С. Бэрх, холхи, нялх, тэлэх, тух D. Асах, хэмх, өчих, буцах, аялах
 Е. Халгах, бээрэх, даарах, гэтэх, төнхөх
25. “Шаргалтан” гэдгийн “-л” хэд дэх бүтээвэр вэ? (2 оноо)
 А. 3 дахь В. 1 дэх С. 4 дэх
 D. 5 дахь E. 2 дахь
26. “Тавь эргэм насны горзгор туранхай хар хүн” гэдэгт хүний хэдэн шинж байна вэ? (2 оноо)
 А. Таван шинж В. Дөрвөн шинж С. Гурван шинж
 D. Хоёр шинж E. Нэг л шинж
27. Дараах үгсийг ажиглан төрөл бус үгийг олно уу. (2 оноо)
 А. Санаа В. Санамж С. Санахуй
 D. Санал E. Сандрал
28. “Үл, эс” гэсэн нэгжийн шинжид тохирохыг сонгоно уу. (2 оноо)
 А. Үгүйсгэх үг В. Үгүйсгэх баймжит бүтээвэр С. Сул үг
 D. Хориглох баймжит бүтээвэр E. Хориглох үг
29. “Шагнуулчаад” гэсэн үгийг бүтцээр нь зөв задалсныг олно уу. (2 оноо)
 А. Шагна - 0 - уул - чих - аад В. Шагна - 0 - уул - ч - х - аад
 С. Шагна - 0 - уул - ч - хаад D. Шан - на - уул - чих - аад
 E. Шан - на - 0 - уул - чих - аад
30. “Илжиг модон хударгандаа” гэсэн хэлцийн гол санааг тодорхойлно уу. (2 оноо)
 А. Дурлан шохоорхох В. Сэтгэл үймрэх
 С. Мэдэмхийрэн онгирох D. Байгаадаа дасал болох
 E. Залхуурах
31. Дараах үгсээс зөв бичсэн бүлэг үгсийг тэмдэглэнэ үү. (2 оноо)
 А. Уяя, бүрхье, мөнхөрнө, эмхэлнэ, малчдадаа
 В. Ачтанаас, жинчидэд, зарчихыг, тохшийг, оёё
 С. Төрөлхтний, хүчтэнээс, идээшинэ, дэвшинэ
 D. Гэнэднэ, онцоллоо, амьдарна, томъёо, шавж
 E. Хонхчны, харьяа, гарчхаад, гэдгэнэх, үндэслэ
32. Өгөх оршихын тийн ялгалын утгуудаас тухайн юманд өртөх утгыг тэмдэглэнэ үү. (2 оноо)
 А. Шуурганд төөр- В. Цээжинд эрдэмгүй- С. Өрөнд ор-
 D. Тэргэнд суу- E. Надад таар-
33. “Бодол” гэсэн үг утгын ямар зүйлчлэлд хамаарах вэ? (2 оноо)
 А. Хүний зүйл В. Хүний бүтээсэн зүйл С. Мэдрэхүйн зүйл
 D. Сэтгэхүйн зүйл E. Зөн билгийн зүйл
34. Өгүүлбэрийг уншаад аман зохиолын ямар зүйлд хамаарахыг тэмдэглэнэ үү. (2 оноо)
- | | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | A. | B. | C. | D. | E. |
|  |  |  |  |  |  |
35. “Дамын үг дамжигтай” гэдгийн “дам”-ыг тэмдэглэнэ үү. (2 оноо)
- | | | | | | |
|--|---|---|---|---|---|
| | A. | B. | C. | D. | E. |
| |  |  |  |  |  |

36. “Нутаг” гэсэн үгэнд бүгд тохирох нөхцөлтэй үгийг олоорой. (2 оноо)
- | | | | | |
|--------------|--------------|--------------|--------------|--------------|
| A. | B. | C. | D. | E. |
| ᠨᠤᠲᠠᠭ . ᠭᠡᠨᠦ | ᠨᠤᠲᠠᠭ . ᠭᠡᠨᠦ | ᠨᠤᠲᠠᠭ . ᠭᠡᠨᠦ | ᠨᠤᠲᠠᠭ . ᠭᠡᠨᠦ | ᠨᠤᠲᠠᠭ . ᠭᠡᠨᠦ |
37. Зөв бичих дүрмийн алдаагүй үгстэй хэсгийг олно уу. (2 оноо)
- | | | | | |
|-----------------------------|-----------------------------|-----------------------------|-----------------------------|-----------------------------|
| A. | B. | C. | D. | E. |
| ᠨᠤᠲᠠᠭ . ᠭᠡᠨᠦ . ᠨᠤᠲᠠᠭ . ᠭᠡᠨᠦ | ᠨᠤᠲᠠᠭ . ᠭᠡᠨᠦ . ᠨᠤᠲᠠᠭ . ᠭᠡᠨᠦ | ᠨᠤᠲᠠᠭ . ᠭᠡᠨᠦ . ᠨᠤᠲᠠᠭ . ᠭᠡᠨᠦ | ᠨᠤᠲᠠᠭ . ᠭᠡᠨᠦ . ᠨᠤᠲᠠᠭ . ᠭᠡᠨᠦ | ᠨᠤᠲᠠᠭ . ᠭᠡᠨᠦ . ᠨᠤᠲᠠᠭ . ᠭᠡᠨᠦ |
38. “Монголын нууц товчоо”-д “Цээлийн ус ширгэв Цэгээн чулуу хагарав” гэж хэн хэлээд Чирха өвгөний нурууг жадлан хөөдөг вэ? (2 оноо)
- | | | |
|-----------------|-----------------------|---------------|
| A. Тодойн Гиртэ | B. Таргуудай Хирилтуг | C. Сорхон Шар |
| D. Дай сэцэн | E. Дайр Үсүн | |
39. “Дуутын хадны шүлэг” хэний зохиол вэ? (2 оноо)
- | | | |
|-----------------|---------------|--------------|
| A. Д.Равжаа | B. Цогт тайж | C. Рашпунцаг |
| D. Лувсанданзан | E. Сагансэцэн | |
40. Зохиолыг дараалуулсан зүй тогтлыг ажиглаад тохирохыг сонгоно уу. (2 оноо)
 Д.Мягмар “Үер”, Ц.Дамдинсүрэн “Зугаацахаар мордсон нь”, Ш.Сүрэнжав “Гар”, С.Эрдэнэ “Сэрүүн дуганын мөхөл”
- | | |
|-----------------------------------|--------------------------------------|
| A. Ч.Лхамсүрэн “Хурандаа” | B. Б.Лхагвасүрэн “Боржигоны бор тал” |
| C. Б.Лхагвасүрэн “Үр могой” | D. Б.Ринчен “Ану хатан” |
| E. Д.Батбаяр “Цахилж яваа гөрөөс” | |

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж:

Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1. Зохиолын нэр ба ишлэлийг зөв харгалзуулаарай.

- | | |
|---|---|
| 1. Чингисийн есөн өрлөгтэй
өнчин хөвгүүний цэцэлсэн шастир | a. “...Алд бие минь алжааваас алжаатугай
Аху төр минь бүү алдартугай...” |
| 2. Чингисийн эр хоёр загалын тууж | b. “...Бор зүрх минь бол бол хийв.
Богино хавирга минь шир шир хийв...” |
| 3. Чингисийн билиг | c. “... Харцага шувууг тэжээж харугана шувуунд
тавибал
Харин дээш хальж хацар зулайд халдах ажгуу...” |
| 4. Гурван зуун тайчуудыг дарсан домог | d. “...Ачит эзэндээ захирагдахад хүрвээс
Арга доор нь дагалдаж яв...” |
| 5. Алтан ордны үйсэн дээрх бичиг | e. “...Сайн моринд эзэн олон биш үү
Өнөр хүнд нөхөр олон биш үү...” |

2.2. Хэлцүүдийг эсрэг утгаар нь зөв харгалзуулаарай.

- | | |
|---|---|
| 1. Шоодох хүний шазуур үмхий | A. Хийморийг нь тугал зажилсан |
| 2. Маргаашийн өөхнөөс өнөөдрийн уушги дээр | B. Мянган өдөр сүүдэр болохоор нэг өдөр хүн бол |
| 3. Ухаанд нь ухна ишиг үхсэн | C. Буруу ишилсэн сүх шиг |
| 4. Барын сүүл болохоор батганы толгой болох | D. Амласнаас атганд буй нь дээр |
| 5. Ямаа гэхээр тэмээ гэх | E. Санаа муут шавар дотортой |

2.3. Хэлц холбоо үгийн хэв шинжийг тохирох үгтэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|------------|---------------------------------|
| 1. ХЗ + ХЗ | A. Хэвлэгдэж байгаа сурах бичиг |
| 2. ХЗ + ҮС | B. Тэр өдрийн баяр хөөр |
| 3. УЗ + ХЗ | C. Үнэний тухай мэдэж байх |
| 4. БЗ + ҮС | D. Айлын зайд толгой хоргодох |
| 5. УЗ + УЗ | E. Аяга ёроолдон сууж байх |

2.4. Найруулгын төрлийг жишээтэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|---------------------------------|--|
| 1. Албан бичгийн найруулга | A. Үлгэн салган биетэй
Үнэгэн сүүлэн малгайтай |
| 2. Эрдэм шинжилгээний найруулга | B. Аргентины шинжээчид үлэг гүрвэлийн одоо
болтол мэдэгдээгүй байгаа нэгэн төрлийг
илрүүлэв. |
| 3. Сонин нийтлэлийн найруулга | C. Та байна аа, нисэхэд суугаад номын сан дээр бууна.
За юу. |
| 4. Уран зохиолын найруулга | D. Химийн шинжилгээний дүнгээс үзэхэд, дэрс
толгойлох үедээ 10-13% протейн, 34-45%
ислэгтэй байна. |
| 5. Ярианы найруулга | E. 5-р зүйл. Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш
байх зарчим. |

ХУВИЛБАР D

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж:

1. Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгавруудыг гүйцэтгээрэй.
2. Эхээс сонгож авсан өгүүлбэр, үгсийг эхтэй нь холбон уншиж ажиглаарай.
3. Сонгох даалгавруудын зөвхөн нэгийг сонгоорой. (Даалгавар бүр 2 оноотой)

Нутгийн тэнхээ

Дөчин таван оны чөлөөлөх дайны үед тэсрэлтэд битүү бэртээд дайны талбарт ухаангүй хэвтэж байсан монгол байлдагчийг зөвлөлтийн цэргийн анги олж хээрийн эмнэлэгт сувилсаар засрал олж амжаагүй тул тэр чигт нь нүүлгэн авч явжээ. Тэр шархтай байлдагч Сибирийн гүнд ухаан орсон боловч хэл орсонгүй. Харин аажимдаа сонсгол орж орос үг дуулсаар орос хэл сурсан боловч монгол хэл нь таг мартагджээ. Төөрч будилсаар арваад жилийн дараа нутагтаа ирээд ганц ч монгол үг мэдэхгүй байхад нь нутгийн хүмүүс гайхаж, зарим нь ч “Ихээхэн маяг сураа шив дээ!” хэмээн муучилж гэнэ. Танил найз нар нь унаа машин олоод төрсөн нутагт нь аваачвал мань хүн Бумбат Улаан Өндөр хэмээх нутгийнхаа уулыг гэнэт таниад баярлахдаа: “Ээ ээ Бумбуут Улан Уундуур! хэмээн хашхирч, далан зад үсрэх мэт болоод монгол хэлээр ярьдаг болсон гэдэг. (Ж.Лхагва)

1. Эхийн үйл явдлыг зөв дараалалд оруулсан хэсгийг олоорой. (2 оноо)
 1. Монгол хэлээр ярьдаг болсон гэдэг
 2. Засрал олж амжаагүй тул тэр чигт нь нүүлгэн авч явжээ
 3. Орос хэл сурсан боловч монгол хэл нь таг мартагджээ
 4. Дөчин таван оны чөлөөлөх дайны үед тэсрэлтэд битүү бэртээд ...
 5. Ихээхэн маяг сураа шив дээ!

A. 4, 2, 5, 3, 1	B. 4, 2, 3, 1, 5	C. 4, 2, 5, 1, 3
D. 4, 2, 3, 5, 1	E. 4, 3, 2, 5, 1	
2. Дээрх эхийн жинхэнэ нэрийг утгаар нь зүйлчилбэл ямар утгын зүйлчлэл байхгүй байна вэ? (2 оноо)

A. Хүний зүйл	B. Гариг эрхсийн зүйл	C. Сэтгэхүйн зүйл
D. Ургамлын зүйл	E. Хүний бүтээсэн зүйл	
3. Дээрх эхийн хэв маягийг тодорхойлно уу. (2 оноо)

A. Тайлбарламж	B. Тоочимж	C. Хүүрнэмж
D. Эргэцүүлэмж	E. Учирламж	

4. Дээрх эх найруулгын ямар төрлөөр бичигдсэн байна вэ? (2 оноо)
 А. Албан бичгийн найруулга В. Эрдэм шинжилгээний найруулга
 С. Уран зохиолын найруулга D. Сонин нийтлэлийн найруулга
 E. Ярианы найруулга
5. Дээрх эхийн сэдвийг олоорой. (2 оноо)
 А. Хүний тусч энэрэнгүй сэтгэлийн тухай В. Дайны хор уршгийн тухай
 С. Нутгаа санасан хүний тухай D. Орос Монголын ахан дүүсийн харилцаа
 E. Төрсөн нутгийн тухай
6. Дээрх эхийн гол санааг илэрхийлсэн тулгуур өгүүлбэрийг олоорой. (2 оноо)
 А. Дайны талбарт ухаангүй хэвтэж байсан монгол байлдагчийг зөвлөлтийн цэргийн анги олж хээрийн эмнэлэгт сувилсаар...
 В. Төөрч будилсаар арваад жилийн дараа нутагтаа ирээд ...
 С. Орос үг дуулсаар орос хэл сурсан боловч монгол хэл нь таг мартагджээ
 D. Ээ ээ Бумбуут Улан Уундуур! хэмээн хашхирч, далан зад үсрэх мэт болоод монгол хэлээр ярьдаг болсон гэдэг.
 E. Тэр шархтай байлдагч Сибирийн гүнд ухаан орсон боловч хэл орсонгүй.
7. Дээрх эх хэдэн цогцолбороос бүтсэн бэ? (2 оноо)
 А. “Дөчин таван оны ... авч явжээ”, “Тэр... хэл орсонгүй”, “Харин ... мартагджээ”, “Төөрч ... муучилж гэнэ”, “Танил найз ... болсон гэдэг” гэсэн 5 цогцолбор
 В. “Дөчин таван оны ... авч явжээ”, “Тэр ... мартагджээ”, “Төөрч ... муучилж гэнэ”, “Танил найз ... болсон гэдэг” гэсэн 4 цогцолбор
 С. “Дөчин таван оны ... авч явжээ”, “Тэр ... мартагджээ”, “Төөрч ... болсон гэдэг” гэсэн 3 цогцолбор
 D. “Дөчин таван оны ... мартагджээ”, “Төөрч ... болсон гэдэг” гэсэн 2 цогцолбор
 E. 1 цогцолбороос бүтсэн бичил эх
8. Дээрх эхийн тулгуур үгсийг зөв бүлэглэсэн хэсгийг олоорой. (2 оноо)
 А. Дайн, байлдагч, тэсрэлт, эмнэлэг, сонсгол, хэл, ухаан, үг, Бумбат Улаан Өндөр, хүмүүс, маяг
 В. Дайн, байлдагч, эмнэлэг, засрал, сонсгол, хэл, ухаан, үг, маяг, уул, хүмүүс
 С. Дайн, байлдагч, тэсрэлт, шарх, эмнэлэг, сонсгол, Сибирь, ухаан, үг, Бумбат Улаан Өндөр, машин
 D. Дайн, байлдагч, зөвлөлтийн цэргийн анги, сонсгол, хэл, ухаан, үг, Бумбат Улаан Өндөр, маяг, унаа, нутаг
 E. Дайн, байлдагч, шарх, зөвлөлтийн цэргийн анги, ухаан, монгол, орос, хэл, үг, нутаг, Бумбат Улаан Өндөр
9. Дараах өгүүлбэрээс шинэ санаа илэрхийлсэн дүрслэх ур маягийг тодорхойлоорой. (2 оноо)
 “Тэр шархтай байлдагч Сибирийн гүнд ухаан орсон боловч...”
 А. Адилтгал В. Ихэсгэл С. Төлөөлөл D. Зүйрлэл E. Хүншүүлэл
10. Дараах тодорхойлолтын цэгийн оронд тохирох үгийг олоорой. (2 оноо)
 Эхийн төгс санаанд зохиогчийн үзэл бодол, хүсэл, санаа сэтгэлийн аяс хөдлөлийг илтгэсэн баймж, үнэлэмж ил ба далд шурган орсныг гэнэ.
 А. Төрсөн санаа В. Гол санаа С. Зорьсон санаа
 D. Шинэ санаа E. Төгс санаа
11. Бүгд баймж, үнэлэмж, сэтгэл хөдлөлийн өнгө аяс илтгэсэн хэсгийг олоорой. (2 оноо)
 А. ...ганц ч, ...зарим нь ч, ...сураа шив дээ!, ...Ээ ээ
 В. ...аажимдаа, ...мэдэхгүй байхад нь, ...ганц ч, ...Ээ ээ, ...баярлахдаа
 С. ...муучилж гэнэ, ...гэнэт, ...сураа шив дээ!, ...ухаангүй
 D. ...таг мартагджээ, ...тэр чигт нь, ...таниад, ...хашхирч
 E. ...ганц ч, ...сураа шив дээ!, ...ярьдаг, ...зад үсрэх
12. Дараах үгсийн аль нь бүхэлзүйжсэн холбоо үг вэ? (2 оноо)
 А. Унаа машин В. Тэр байлдагч С. Төөрч будил
 D. Жилийн дараа E. Мэдэхгүй байхад
13. “...намайг шийтгүүлж ял хүлээхэд...” гэхэд “намайг” гэсэн үг өгүүлбэрт ямар гишүүн болох вэ? (2 оноо)
 А. Өгүүлэгдэхүүн В. Тодотгол С. Байц
 D. Шууд бус тусагдахуун E. Тусагдахуун
14. “Гэвч хүү нь эхийнхээ сэтгэлийг мэдэрсэн нь аз, хожуу ч гэсэн ухаарсан нь зол” гэсэн өгүүлбэр хэлэх зорилго, аялгаараа ямар өгүүлбэр вэ? (2 оноо)
 А. Асуух өгүүлбэр В. Анхааруулах өгүүлбэр С. Хүүрнэх өгүүлбэр
 D. Захирах өгүүлбэр E. Батлах өгүүлбэр

15. “Үүнийг үзээд миний элэг эмтрэх шиг, зүрх зүсэгдэх шиг болов” гэсэн өгүүлбэрийн дүрслэх ур маягийг ол. (2 оноо)
 А. Зүйрлэл В. Адилтгал С. Хэтрүүлэл
 D. Төлөөлөл E. Ёгтлол
16. “Ээж ээ, хүү чинь таныгаа **баярлуулахаас илүү гомдоосон, хайрлахаасаа илүү зовоосон нь** олон билээ” гэсэн өгүүлбэр дэх онцолсон үгс утгын ямар харьцаанд байна вэ? (2 оноо)
 А. Ойролцоо утгын В. Эсрэг утгын С. Төсөө утгын
 D. Зүйлчилсэн утгын E. Өвөрмөц хэлцийн
17. “Аадар бороо байн байн орж газрыг ундаалан цэцэг ногоо өвч дэлгэрсэн энэ зуны сайхныг хэлэх үү” гэсэн өгүүлбэрийн **бороо – газар** гэсэн үйлдэгчийн харьцааг зөв тодорхойлсныг олоорой. (2 оноо)
 А. Эдлэн ба сөрөн үйлдэгч В. Аяндаа ба өртөн үйлдэгч
 С. Эрхэн ба өртөн үйлдэгч D. Аяндаа ба бүтээн үйлдэгч
 E. эрхэн ба эдлэн үйлдэгч
18. “Хэрлэнгийн баруун биеийн уулс униартаж зүүнийг барин намсан намссаар газар тэнгэр заагласан нарийхан хөх зурвас болон хөмсөглөжээ” гэсэн өгүүлбэрт дүрслэгдэж буй “зурвас” гэдэг нь юуг дүрсэлсэн бэ? (2 оноо)
 А. Гол В. Зам С. Уул D. Нарны туяа E. Униар
19. “Үд өнгөрч халуу шатах янзтай” гэсэн өгүүлбэрийг салаалан хувиргасныг олоорой. (2 оноо)
 А. Нар дээр хөөрч халуу шатах янзтай.
 В. Нар хоймор голлож халуу шатах янзтай.
 С. Нар хэвийж халуу шатах янзтай.
 D. Нар ханын толгойд тусаж халуу шатах янзтай.
 E. Нар тоононд тусаж халуу шатах янзтай.
20. Аливаа өгүүлбэрийг ойролцоо утга санаагаар хувиргаж бичвэл: (2 оноо)
 А. Салаалсан өгүүлбэр бүтнэ В. Тонгоргосон өгүүлбэр бүтнэ
 С. Хураангуйлсан өгүүлбэр бүтнэ D. Дэлгэрүүлсэн өгүүлбэр бүтнэ
 E. Нийлмэл өгүүлбэр бүтнэ
21. “Аадар бороо байн байн орж газрыг ундаалан цэцэг ногоо өвч дэлгэрсэн энэ зуны сайхныг хэлэх үү” гэсэн өгүүлбэрийн баймж үнэлэмжийг тайлбарла. (2 оноо)
 А. Үйл байдлын уйтгар гунигтайг илэрхийлжээ
 В. Үйл байдлын баяр бахдалтайг илэрхийлжээ
 С. Үйл байдлын дуу хууртайг илэрхийлжээ
 D. Үйл байдлыг сэтгэлд зохистойг илэрхийлжээ
 E. Үйл байдлын хөөр хөгжөөнтэйг илэрхийлжээ
22. “Дун цагаан хун” гэдэгтэй адил утга бүтэц бүхий хэсгийг олоорой. (2 оноо)
 А. Ув улаан сарнай В. Хурдан цагаан хүлэг С. Цагаан шар царай
 D. Цагаан үнэгэн малгай E. Алтан шар зам
23. “Уулсын суга” гэдгийн утга нь (2 оноо)
 А. Уулын орой хэсэг В. Уулын ар хормой С. Уулын бэл газар
 D. Уулын хажуу завсар E. Уулын хэвгий тал
24. Бүгд үйл үг байгаа хэсгийг олоорой. (2 оноо)
 А. Чимх, цөлх, хөгнөх, тойлох, тах В. Сүйх, хэмх, халх, сэрх, сэвх
 С. Эргэх, шуудрах, ширвэх, чихдэх, цуулах D. Шовх, чих, хавх, тэх, өөх
 E. Харх, бурхи, дархи, салхи, бэрх
25. “Гялтганах” гэдгийн “-гана” хэд дэх бүтээвэр вэ? (2 оноо)
 А. 3 дахь В. 1 дэх С. 4 дэх D. 5 дахь E. 2 дахь
26. “Хараа алдрам урт ногоон хөндий” гэдэгт хөндийн хэдэн шинж байна вэ? (2 оноо)
 А. Таван шинж В. Дөрвөн шинж С. Гурван шинж
 D. Хоёр шинж E. Нэг л шинж
27. Дараах үгсийг ажиглан төрөл биш үгийг олно уу. (2 оноо)
 А. Суудал В. Сууц С. Суусар
 D. Суурь E. Суулгац
28. “Амьтны нялх үр сүүдэр тусахад л хиртэм тийм ариухан аж” гэсэн өгүүлбэрийн “аж” гэдэг нь хэлний ямар нэгж вэ? (2 оноо)
 А. Сул баймжит бүтээвэр В. Үйл үг С. Туслах үг
 D. Дутмаг үйл үг E. Сул үг
29. Аль нь үгийн сангийн үндсэн утгаа хадгалж байна вэ? (2 оноо)
 А. Дуу барих В. Зай барих С. Гар барих
 D. Элэг барих E. Цаг барих

30. “Султгачхаад” гэсэн үгийг бүтцээр нь зөв задалсныг олно уу. (2 оноо)
 А. Сул - т - га - ч - х - аад В. Сул - д - га - 0 - чих - аад
 С. Сул - тга - чих - аад D. Сул - т - га - 0 - чих - аад E. Сул - д - га - чих - аад
31. “Сүүнд халсан хүн тараг үлээх” гэсэн хэлцийн утгыг тодорхойлно уу. (2 оноо)
 А. Хашрах В. Андуурах С. Халууцах
 D. Мэдрэх E. Ичих, сандрах
32. Дараах үгсээс зөв бичсэн бүлэг үгсийг тэмдэглэнэ үү. (2 оноо)
 А. Гилтэгнэ, шаагьж, дохигоно, зогьс В. Харьяа, тусал, ганзага, дэвтэрлэ
 С. Хөөө, эрмэлзлэл, тасал, хагарчхав D. Нулимас, засварласан, гуравласан
 E. Нөхцлийг, санаачилга, хашхирах
33. “Сүүдэр” гэсэн үг утгын ямар зүйлчлэлд хамаарах вэ? (2 оноо)
 А. Мэдрэхүйн зүйл В. Зөн билгийн зүйл
 С. Хүний бүтээсэн зүйл D. Эс бүтээсэн зүйл E. Сэтгэхүйн зүйл
34. Өгүүлбэрийг уншаад аман зохиолын ямар төрөл зүйл болохыг тодорхойлоорой. (2 оноо)
- | | | | | | |
|--|--------------|--------------|--------------|--------------|--------------|
| | A. | B. | C. | D. | E. |
| | ᠰᠤᠯᠤᠭᠠᠬᠠᠭᠠᠳᠤ | ᠰᠤᠯᠤᠭᠠᠬᠠᠭᠠᠳᠤ | ᠰᠤᠯᠤᠭᠠᠬᠠᠭᠠᠳᠤ | ᠰᠤᠯᠤᠭᠠᠬᠠᠭᠠᠳᠤ | ᠰᠤᠯᠤᠭᠠᠬᠠᠭᠠᠳᠤ |
35. “Асар майхан” гэсэн холбоо үгийн “асар” гэсэн үгийг зөв бичсэнийг олоорой. (2 оноо)
- | | | | | |
|------|------|------|------|------|
| A. | B. | C. | D. | E. |
| ᠠᠰᠢᠷ | ᠠᠰᠢᠷ | ᠠᠰᠢᠷ | ᠠᠰᠢᠷ | ᠠᠰᠢᠷ |
36. “Бөх” гэдэг үгэнд бүгд тохирох нөхцөлтэй хэсгийг олоорой. (2 оноо)
- | | | | | |
|------|------|------|------|------|
| A. | B. | C. | D. | E. |
| ᠪᠥᠬᠡ | ᠪᠥᠬᠡ | ᠪᠥᠬᠡ | ᠪᠥᠬᠡ | ᠪᠥᠬᠡ |
37. Бүх үг нь холбох эгшгийн дүрмээр бичсэн хэсгийг олоорой. (2 оноо)
- | | | | | |
|------|------|------|------|------|
| A. | B. | C. | D. | E. |
| ᠪᠥᠬᠡ | ᠪᠥᠬᠡ | ᠪᠥᠬᠡ | ᠪᠥᠬᠡ | ᠪᠥᠬᠡ |
38. “Цаасан шувууны үлгэр” хэний бүтээл болохыг тэмдэглэнэ үү. (2 оноо)
 А. Цогт тайж В. Д. Равжаа С. Лувсанданзан
 D. Инжинааш E. Гэлэгбалсан
39. Зохиолыг дараалуулсан зүй тогтлыг олоод тохирохыг нөхнө үү. (2 оноо)
 Ч.Лодойдамба “Солонго”, М.Ядамсүрэн “Турван хүүхэн”, Д.Пүрэвдорж “Ширмэн цөгцний дууль”

 А. Б.Лхагвасүрэн “Буруу энгэртэй дээл” В. Ш.Сүрэнжав “Багш”
 С. С.Пүрэв “Азын цэнхэр уул” D. С.Эрдэнэ “Сэрүүн дуганы мөхөл”
 E. Д.Мягмар “Үер”

40. “Монголын нууц товчоо” зохиолд “Хурганы үс гуужив, төлөгний үс төлжив” гэж хэн хэлдэг вэ? (2 оноо)
- A. Дай сэцэн
B. Тодойн Гиртэ
C. Таргуудай Хирилтүг
D. Ван хаан
E. Жаха Хамбу

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж:

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй. (5 оноо)
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.
- 2.1. Зохиолын нэр ба ишлэлийг зөв харгалзуулаарай. (5 оноо)
1. Сэтгэлийг амраагч
A. “...Баясгалантай хөөрхөн царайг чинь хө
Бахархаад бахархаад баршгүй
Баярыг улам арвитгамаар хө...”
2. Ичиг ичиг
B. “...Насны багад эрдэм сурахад
Залхуугүй бол даанч сайн...”
3. Дөрвөн улирал
C. “...Аяа бас, төрийг цуугиулагч түшмэд ичиг
Аяа бас, номыг үл сурагч элдвийг сурагч банди нар ичиг...”
4. Цаасан шувуу
D. “...Найман чөлөөт хүний биеийг олсноо
Насны идрийн цогоор нөгцөөв л...”
5. Үлэмжийн чанар
E. “...Ачийн хариуг мэдэх хүн цөөн
Хилэнцийг мэдэвч хийх хүн олон...”
- 2.2. Хэлцүүдийг эсрэг утгаар нь зөв харгалзуулаарай. (5 оноо)
1. Зүрх нь үх-
A. Ааг нь буцал-
2. Хулхи нь буу-
B. Хөрөнгөндөө сага-
3. Хөг нь өнгөр-
C. Ааг нь эрчил-
4. Хоног төөрүүл-
D. Чихний чимэг бол-
5. Чихний чийр бол-
E. Зориг нь бадар-
- 2.3. Хэлц холбоо үгийн хэв шинжийг тохирох үгтэй нь зөв харгалзуулаарай. (5 оноо)
1. ХЗ + ХЗ
A. Монгол Улсын үндсэн хууль
2. ҮС + ҮС
B. Энэ өдрийн амар амгалан
3. ХЗ + УЗ
C. Мэдэхийн тулд судалж үзэх
4. БЗ + ҮС
D. Алтан үеийнхний авьяас билэг
5. УЗ + ҮС
E. Оддын дунд бодол бэлчих
- 2.4. Найруулгын төрлийг жишээтэй нь зөв харгалзуулаарай. (5 оноо)
1. Албан бичгийн найруулга
A. Мод шатаах, органик бодисын исэлдэлтээр 1.7 тэрбум
тонн нүүрсхүчлийн хий ялгардаг.
2. Эрдэм шинжилгээний найруулга
B. Эрүүл энх жаргаж яваарай
Их үйлсийг бүтээж яваарай
3. Сонин нийтлэлийн найруулга
C. Төв талбайг та мэднэ тээ? Төв холбооны хажууханд
4. Уран зохиолын найруулга
D. Монгол Улсад эрдмийн зэргийг шинжлэх ухааны доктор,
дэд доктор, эрдмийн цолыг профессор, дэд профессор
байхаар тогтоосугай.
5. Ярианы найруулга
E. Газрын харилцаа геодез зураг зүйн газраас аймгийн газрын
албадад тоног төхөөрөмж өгөхөөр боллоо.

2011 оны Монгол хэлний хичээлийн даалгаврын түлхүүр

№	ХУВИЛБАНУУД			
	A	B	C	D
1	C	A	E	D
2	B	C	D	D
3	B	E	A	C
4	B	A	C	C
5	A	D	C	E
6	B	D	D	D
7	C	E	B	B
8	D	B	A	E
9	C	A	C	C
10	B	D	B	C
11	A	A	E	A
12	D	D	B	B
13	A	A	B	A
14	C	E	B	C
15	E	C	B	A
16	A	A	C	B
17	D	A	C	B
18	B	A	E	C
19	B	B	B	D
20	A	C	B	A
21	E	E	D	D
22	C	A	E	E
23	B	A	C	D
24	B	D	B	C
25	E	C	A	E
26	E	C	B	C
27	B	A	E	C
28	C	C	A	D
29	D	C	D	C
30	D	D	D	E
31	E	E	A	E
32	B	C	A	B
33	B	E	D	D
34	E	D	A	E
35	C	E	A	B
36	C	A	D	A
37	A	B	B	B

38	A	D	B	B
39	D	B	B	C
40	E	C	E	C
2.1	1c 2d 3a 4e 5b	1c 2b 3e 4a 5d	1c 2e 3a 4b 5d	1b 2c 3d 4e 5a
2.2	1d 2c 3b 4e 5a	1b 2d 3e 4a 5c	1e 2d 3a 4b 5c	1c 2e 3a 4b 5d
2.3	1e 2c 3d 4a 5b	1e 2c 3a 4b 5d	1c 2a 3e 4b 5d	1c 2a 3e 4b 5d
2.4	1c 2a 3d 4e 5b	1c 2a 3d 4e 5b	1e 2d 3b 4a 5c	1d 2a 3e 4b 5c